



МОНГОЛ УС ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.БИЛЭГСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/447
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Монгол ус ТӨААТҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол ус ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Аудитаар дараах зөрчил илэрсэн нь санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Төсөл хөтөлбөртэй холбоотой гэрээт ажлын үлдэгдэл төлбөр болох 40,000.0 мянган төгрөгийг байгууллагын өр төлбөрөөр бүртгээгүй. Мөн дээрх төслийг хэрэгжүүлэх үед байгууллагын талаас хариуцлага алдсан, төлөвлөгөөг сайтар боловсруулаагүй зэргээс шалтгаалж шүүхийн тогтоолоор гэрээт ажлыг гүйцэтгэгч

талд 2,500.0 мянган төгрөгийн нэмэлт зардлыг төлсөн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1 дэх заалтуудыг зөрчсөн.

- Байгууллагын өмнөх дарга, 2015 онд байсан ерөнхий нягтлан нар өөрийн эзэмшилд байсан 6,649,0 мянган төгрөгийн өртөгтэй 3 ширхэг компьютерийг байгууллагад хүлээлгэн өгөөгүй. Мөн Төв аймгийн Эрдэнэ сумд байрлах "Туул голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх төсөл"-тэй холбоотой байгууламжийг харуул хамгаалалтгүй үлдээснээс 8,000.0 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө дутагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.1 "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ... ашиглах", 67 дугаар зүйл дэх дотоодын хяналт шалгалт зэрэг заалтыг зөрчсөн.
- Хангамжийн материал 11,658.1 мянган төгрөг, шатахуун 9,286.0 мянган төгрөг, бичиг хэрэг 3,361.9 мянган төгрөг, нийт 24,306.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод хүлээж авалгүйгээр шууд зарлагад бичилт хийсэн. Энэ нь НББОУС 2-ын "Бараа материал-д заасны дагуу худалдаж авсан үнийн дүнгээр орлогод авч зарцуулсан хэмжээгээр зарлагдах" болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



МОНГОЛ УС ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Аудитын тайлан

**САГ-ын дарга, тэргүүлэх
аудитор: Ц. Наранчимэг**

Утас: 261663

Цахим хаяг:

naranchimegts@audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитын менежер:

Я.Самбууням

Утас: 260512

Цахим хаяг:

sambuunyamyia@audit.gov.mn

Ахлах аудитор: Н. Батсайхан

Утас: 260512

Цахим хаяг:

batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр

Бага тойруу 6 Улаанбаатар -

46

Цахим хуудас:

“СМД” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч

Д.Гэндэнпэлжээ

Утас: 99172936,

Аудитын менежер:

Б.Жаргал

Ахлах аудитор: Я.Чойжилсүрэн

Аудиторын туслах: Б.

Мөнхцацрал

Утас: 99110699, 99175995

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/32/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол ус ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Сангийн Сайдын 249 дүгээр тушаал "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар", 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Сангийн Сайдын 77 дугаар тушаал "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал"-ын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 28-наас 2017 оны 02 дугаар сарын 24-ныг хүртэл хийхээр төлөвлөн аудитын багийн гишүүнээр "СМД Аудит" ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Д.Гэндэнпэлжээ, чанарын хяналтын менежер Б.Жаргал нар удирдан зохион байгуулж, "СМД Аудит" ХХК-ийн ахлах аудитор Я.Чойжилсүрэн, туслах аудитор Б.Мөнхцацрал нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 25-нд "СМД Аудит" ХХК-д ирүүлсэн байна.

"СМД Аудит" ХХК 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийг 2016 оны 09 дугаар сарын 28-наас 2016 оны 11 сарын 16-ны хооронд, завсрын аудитыг 2016 оны 10 дугаар сарын 03 -аас 11 дугаар сарын 16-ны хооронд хийж 2016 оны эхний 9 сарын байдлаарх санхүүгийн баримтуудыг хамруулсан. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-наас 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд Монгол ус ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулсан болно.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Монгол ус ТӨААТҮГ нь 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, 2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, 1994 оны 5 дугаар сарын 31-ны өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тухай” хууль, 2001 оны 02 дугаар сарын 01-ны өдөр батлагдсан “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль, 1999 оны 05 дугаар сарын 14-ны өдөр батлагдсан “Хөдөлмөрийн тухай” хууль, 1998 оны 01 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Архивын тухай” хууль, 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Сангийн Сайдын 77 дугаар тушаал, 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Сангийн Сайдын 249 дугаар тушаал зэрэг хууль, холбогдох эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгууллага нь "Монгол улсын нутаг дэвсгэрт усны менежмент хийх, Монгол улсын Усны тухай хууль бусад хуульд нийцүүлэн “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, усны нөөцийн менежмент хийх, төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж, түүний ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллах үндсэн чиг үүрэгтэй” ажиллаж байна.

Монгол ус ТӨААТҮГ-ын нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж байна.

Монгол ус ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Монгол ус ТӨААТҮГ-ын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын 8 чиглэлээр 45 хяналтын горим, нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Монгол ус ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан эмхтгэл болгон мөрддөг ба хамгийн сүүлд 2013 оны 1 сараас эхлэн шинэчилсэн хувилбарыг мөрдөн ажиллаж байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна.

Бид Монгол ус ТӨААТҮГ-ын ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Монгол ус ТӨААТҮГ санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Интерактив ХХК-ын “Даймонд” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Уг програм нь СТОУС болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн тул Сангийн яамнаас ашиглах зөвшөөрөл авсан байна.

5. Материаллаг түвшин

Материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд нийт орлогын 2 хувиар авах нь зохимжтой гэж үзсэн. Нийт орлогыг материаллаг байдлын суурь болгоход ашигласан үндэслэл нь тус байгууллага өөрийн санхүүжилтийг 100 хувь бүрдүүлдэг байна. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт орлогын 2 хувиар үргэлжлүүлэн сонгосон бөгөөд энэ нь 16,629.6 мянган төгрөг болж байна.

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол ус ТӨААТҮГ-ын дотоод хяналтын үйл ажиллагааг асуулга, ажиглалтын горимоор хянаж, санхүүгийн үйл ажиллагааны журам, санхүүгийн албадын бүтэц, зохион байгуулалтыг хангалттай гэж дүгнэсний үндсэн дээр хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Монгол ус ТӨААТҮГ-ын төсвийн шууд захирагч нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар байгууллагын үйл ажиллагаанаас 831,477.5 мянган төгрөгийн орлого олж, үүнээс 672,002.4 мянган төгрөгийн зардал гаргаж тайлант онд татварын дараах ашиг 148,041.2 мянган төгрөг болсон байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Монгол ус ТӨААТҮГ нь шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн <https://shilendans.gov.mn/org/5192> сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу сар бүр шилэн дансанд байршуулаагүй байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу 49 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 8 дансанд нийт 45 горим, сорил гүйцэтгэв.

Өмнөх онд алданги, торгууль төлсөн, байгууллагын өглөгийг бүртгэлд тусгаагүй, найдваргүй авлага үүссэн, хөрөнгө дутагдсан, ажлын баримтгүй зардлын гүйлгээ хийсэн, бараа материалыг холбогдох дансанд бичилт хийлгүйгээр шууд зардлын дансанд бичилт

хийсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдэлүүд нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах, зардлыг илүү, дутуу тооцох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Монгол ус ТӨААТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээний 80 хувийг эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Экспресс трейд ХХК-тай 2013 онд “Туул голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх” төслийн хүрээнд нийт 100,000.0 мянган төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулсан бөгөөд 2013 оны 2 сард ажлыг бүрэн хүлээж авсан боловч үлдэгдэл төлбөр болох 40,000.0 мянган төгрөгийг байгууллагын өр төлбөрөөр бүртгээгүй. Энэ нь АОУС-ын эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1-д заасны дагуу “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” заалтыг зөрчиж байна. Мөн дээрх төслийг хэрэгжүүлэх үед байгууллагын талаас хариуцлага алдсан, бэлтгэл ажлыг сайтар хангаагүй зэргээс шалтгаалж 2016 оны 1 дүгээр сард шүүхийн шийдвэр гарч гэрээт ажлыг гүйцэтгэгч талд 2,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй нэмэлт зардлыг төлсөн байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Тус байгууллагын өмнөх захирал өөрийн эзэмшиж байсан 2,300.0 мянган төгрөгийн үнэтэй зөөврийн компьютер, 3,399.0 мянган төгрөгийн үнэтэй суурин компьютерыг, 2015 онд байсан ерөнхий нягтлан бодогч өөрийн 950,0 мянган төгрөгийн үнэтэй зөөврийн компьютерыг тус тус байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна. Мөн Төв аймгийн Эрдэнэ сумд байрлах “Туул голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх төсөл”-тэй холбоотой байгууламжийг харуул хамгаалалтгүй үлдээснээс 8,000.0 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө дутагдсан. Энэ нь Төрийн

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.1 “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ... ашиглах”, 67 дугаар зүйл дотоодын хяналт шалгалт зэрэг заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Нийт 1,405.8 мянган төгрөгийн анхан шатны дэмжих баримтгүй эсвэл хувь хүний хүчингүй тамга, тэмдэгтэй зардлыг бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д заасан “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчиж байна. Мөн байгууллагын даргын гар утасны лизингийн төлбөрийг тайлант онд шууд зардлаар бүртгэсэн. Энэ нь НББОУС 17 Түрээс-ийн стандартыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Голомт банкнаас 2013 онд 60,000.0 мянган төгрөгийн зээл авсан ба зээлийн төлбөрийн хугацаа хэтрүүлсний торгуульд 7,000.0 мянган төгрөг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.3-д заасан "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" зарчмыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

5. Хангамж материал 11,658.1 мянган төгрөг, шатахуун 9286.0 мянган төгрөг, бичиг хэргийн 3,361.9 мянган төгрөгийн нийт 24,306.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод хүлээж авалгүйгээр шууд зарлагад бичилт хийсэн. Энэ нь НББОУС 2 Бараа материал-д заасны дагуу худалдаж авсан үнийн дүнгээр орлогод авч зарцуулсан хэмжээгээр зарлагадна гэснийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

12. Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс гарсан 0.0 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

13. Анхаарал татахуйц бүсэд чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 89,860.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 89,860.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажилласан болно. Дээрх алдаа, зөрчлөөс хэв шинжийн хувьд материаллаг гэж үзэж болохуйц 63,054.80 мянган төгрөгийн алдаа, зөрчил гарсан байна. Энэ нь төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатан дахь материаллаг түвшингийн хэмжээнээс 46,425.20 мянган төгрөгөөр илүү гарч байна.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2015 оны тайланд “СМД” Аудит ХХК хийж нийт 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн 50 хувийг хэрэгжүүлсэн ба авлагатай холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

17. Хязгаарлалттай санал дүгнэлт

Төсөл хөтөлбөртэй холбоотой гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийг байгууллагын өр төлбөрөөр бүртгээгүй, зээлийн төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүйгээс алданги торгууль төлсөн, хөрөнгө дутагдуулсан зэргийг эс тооцвол Монгол ус ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УС ТӨААТҮГ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 1: Өглөг11

Асуудал 2: Үндсэн хөрөнгө12

Асуудал 3: Зардал13

2017 оны 02 дугаар сар 24

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитын газар нь аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгасан. Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитыг хэрэгжүүлэх явцад дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системийг судлах
- Санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын үйл ажиллагааг тодорхойлж, эрсдэлийг үнэлэх
- Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, журналаас ажил гүйлгээг хөөн шалгаж үлдэгдлийг тохируулах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол ус ТӨААТҮГ байгууллагын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

Асуудал – 1: Өр төлбөр**Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт:**

- Экспресс трейд ХХК-тай 2013 онд “Туул голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх” төслийн хүрээнд нийт 100,000.0 мянган төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулсан бөгөөд 2013 оны 2 сард ажлыг бүрэн хүлээж авсан боловч үлдэгдэл төлбөр болох 40,000.0 мянган төгрөгийг байгууллагын өр төлбөрөөр бүртгээгүй. Энэ нь АОУС-ын эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1-д заасны дагуу “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” заалтыг зөрчиж байна. Мөн дээрх төслийг хэрэгжүүлэх үед байгууллагын талаас хариуцлага алдсан, бэлтгэл ажлыг сайтар хангаагүй зэргээс шалтгаалж 2016 оны 1 дүгээр сард шүүхийн шийдвэр гарч гэрээт ажлыг гүйцэтгэгч талд 2,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй нэмэлт зардлыг төлсөн байна.

Эрсдэл:

- Холбогдох хууль, заавар, журам зөрчсөн байх;
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- Өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байх;

Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1-д заасны дагуу “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэснийг мөрдлөг болгох. Мөн гэрээт ажилд хүндрэл учруулж болох аливаа асуудлыг урьдчилан тооцоолж, үүнээс сэргийлэх арга хэмжээг богино хугацаанд авч байвал зохино.

Үйлчлүүлэгчийн хариу:

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Асуудал – 2: Үндсэн хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт:**

- Тус байгууллагын өмнөх захирал өөрийн эзэмшиж байсан 2,300.0 мянган төгрөгийн үнэтэй зөөврийн компьютер, 3,399.0 мянган төгрөгийн үнэтэй суурин компьютерыг, 2015 онд байсан ерөнхий нягтлан бодогч өөрийн 950,0 мянган төгрөгийн үнэтэй зөөврийн компьютерыг тус тус байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна. Мөн Төв аймгийн Эрдэнэ сумд байрлах “Туул голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх төсөл”-тэй холбоотой байгууламжийг харуул хамгаалалтгүй үлдээснээс 8,000.0 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө дутагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.1 “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ... ашиглах”, 67 дугаар зүйл дотоодын хяналт шалгалт зэрэг заалтыг зөрчиж байна.

Эрсдэл:

- Данс бүртгэлд байгаа хөрөнгө өөрийн эзэмшилд биетээр байхгүй байх;
- Хөрөнгийн тооллогоор хөрөнгө дутагдах;

Зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн албаны дарга, эд хариуцагч нар байгууллагын дарга, ажилтан нар ажил үүргээ солилцсон үед тухайн дарга, ажилтантай холбоотой эд хөрөнгийг бүртгэн авч, тойрох хуудсыг бүрдүүлж байх шаардлагатай.

Үйлчлүүлэгчийн хариу:

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Асуудал – 3: Зардал**Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт:**

- Нийт 1,405.8 мянган төгрөгийн анхан шатны дэмжих баримтгүй эсвэл хувь хүний хүчингүй тамга, тэмдэгтэй зардлыг бүртгэсэн. Энэ нь 7 дугаар зүйл 7.7-д заасан “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчиж байна. Мөн байгууллагын даргын гар утасны лизингийн төлбөрийг тайлант онд шууд зардлаар бүртгэсэн. Энэ нь НББОУС 17 Түрээс-ийн стандартыг зөрчиж байна.

Эрсдэл:

- Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэхгүй байх;

Зөвлөмж:

Өр төлбөрийг цаг тухайд нь барагдуулж нэмэлт үр ашиггүй хүү, алданги бодуулахгүй байхад анхаарч ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу:

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

МОНГОЛ УС ТӨААТҮГ ХХК**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**ХӨРӨНГӨ:**

	лав	2016.01.01 MNT	2016.12.31 MNT
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		7,275,764.83	63,269,248.98
Дансны авлага		181,715,408.30	180,070,308.30
Татвар НДШ-ийн авлага		-	557,980.79
Бараа материал		1,341,818.19	1,341,818.19
Урьдчилж төлсөн зардал (тооцоо)		2,363,106.70	2,363,106.70
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		192,696,098.02	247,602,462.96

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө		1,212,021,248.78	1,613,850,147.12
Биет бус хөрөнгө		1,902,169.00	457,489.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,213,923,417.78	1,614,307,636.12
НИЙТ ХӨРӨНГӨ		1,406,619,515.80	1,861,910,099.08

ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ:

	лав		
БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГ			
Дансны өглөг		51,993,743.00	16,383,310.00
Цалингийн өглөг		58,547,462.30	7,320,659.90
Татварын өглөг		23,807,404.37	13,158,025.95
НДШ-ийн шимтгэлийн өглөг		8,590,291.24	629,066.24
Банкны зээл		35,000,000.00	-
Хүүний өглөг		15,689,975.12	
БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГИЙН ДҮН		193,628,876.03	37,491,062.09

УРТ ХУГАЦААТ ӨГЛӨГ

Урт хугацаат өглөг		-	-
УРТ ХУГАЦААТ ӨГЛӨГИЙН ДҮН		-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨР		193,628,876.03	37,491,062.09

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Төрийн өмч		1,204,119,948.29	1,674,923,107.29
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		8,870,691.48	149,495,929.70
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН		1,212,990,639.77	1,824,419,036.99
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ		1,406,619,515.80	1,861,910,099.08

-

-

МОНГОЛ УС ТӨААТҮГ ХХК

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	лав	2016.01.01 MNT	2016.12.31 MNT
БОРЛУУЛАЛТ		545,603,057.12	830,424,075.85
БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ		151,212,215.27	207,040,450.08
НИЙТ АШИГ		394,390,841.85	623,383,625.77
Хүүний орлого		90,716.01	1,053,470.85
Ерөнхий ба удирдлагын зардал		353,040,763.84	443,131,908.22
Бусад зардал		240,909.09	21,830,012.52
Гадаад валюттийн ханшийн зөрүүгийн олз (гарз)		-	10,504.50
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			5,004,561.30
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		<u>41,199,884.93</u>	<u>164,490,241.68</u>
Орлогын татварын зардал		4,119,988.49	16,449,024.17
Татварын дараах ашиг (алдагдал)		<u>37,079,896.44</u>	<u>148,041,217.51</u>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахи ашиг (алдагдал)			
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)		<u>37,079,896.44</u>	<u>148,041,217.51</u>
Бусад дэлгэрэнгүй орлого			
ОРЛОГЫН НИЙТ ДҮН		<u>37,079,896.44</u>	<u>148,041,217.51</u>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

МОНГОЛ УС ТӨААТҮГ ХХК

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад вадютийн хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Дүн
2014 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,204,119,948.29	-	-	-	-	-	(28,209,204.96)	1,175,910,743.33
НББ-ийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
Залруулсан үлдэгдэл	1,204,119,948.29	-	-	-	-	-	(28,209,204.96)	1,175,910,743.33
Тайлант үеийн ашиг (алдагдал)							37,079,896.44	37,079,896.44
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт								-
Зарласан ногдол ашиг								-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
2015 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,204,119,948.29	-	-	-	-	-	8,870,691.48	1,212,990,639.77
НББ-ийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
Залруулсан үлдэгдэл	1,204,119,948.29	-	-	-	-	-	8,870,691.48	1,212,990,639.77
Тайлант үеийн ашиг (алдагдал)							148,041,217.51	148,041,217.51
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт	470,803,159.00							470,803,159.00
Зарласан ногдол ашиг							7,415,979.29	7,415,979.29
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
2016 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,674,923,107.29	-	-	-	-	-	149,495,929.70	1,824,419,036.99

-

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

МОНГОЛ УС ТӨААТҮГ ХХК
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	2016.01.01	2016.12.31
	MNT	MNT
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</u>	432,321,060.85	869,179,467.92
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	432,321,060.85	869,179,467.92
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	426,560,035.62	736,749,959.12
Ажиллагчдад төлсөн	188,165,534.70	380,124,217.69
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,140,310.28	70,650,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	14,721,009.27	5,747,473.26
Ашиглалтын зардалд төлсөн		8,184,018.82
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	80,369,100.03	44,743,691.00
Хүүний төлбөрт төлсөн	1,750,000.00	22,689,975.12
Татварын байгууллагад төлсөн	30,279,952.22	59,556,660.45
Даатгалын төлбөрт төлсөн		514,830.00
Бусад мөнгөн зарлага	58,134,129.12	144,539,092.78
<u>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	5,761,025.23	132,429,508.80
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</u>	90,716.01	1,053,470.85
Хүлээн авсан хүүний орлого	90,716.01	1,053,470.85
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	-	42,500,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		42,500,000.00
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	90,716.01	(41,446,529.15)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
<u>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</u>	-	16,014.03
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		16,014.03
<u>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	-	35,005,509.53
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		35,000,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		5,509.53
<u>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	-	(34,989,495.50)
Валютын ханшийн зөрүү		
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,851,741.24	55,993,484.15
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,424,023.59	7,275,764.83
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,275,764.83	63,269,248.98
	(0.00)	-